



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 386

Улаанбаатар хот

Г “Эрэнцав” ХК-ийн үнэт цаасны 7
арилжааг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 77 дугаар тогтоолын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрэнцав” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.

2. “Эрэнцав” ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор “ҮЦТТТХТ” ХХК дахь данс нь нээгдээгүй байгаа хувьцаа эзэмшигчдийн дансыг компанийн санхүүжилтээр нээлгэхийг “Эрэнцав” ХК/Г.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

4. “Эрэнцав” ХК-ийн хувьцаа эзэмшигч Б.Цэдэн, О.Самедов нарын өмчилж байгаа “Эрэнцав” ХК-ийн нийт гаргасан хувьцааны 51% буюу 50,857 /тавин мянга найман зуун тавин долоо/ ширхэг хувьцааг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн нэг жилийн хугацаатайгаар тусгаарлахыг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын 4 дэх заалтаар тусгаарлалт хийсэн нь нэр дурдагдсан 2 хувьцаа эзэмшигчдийн хооронд үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх ажиллагааг хязгаарлахгүй болохыг тэмдэглэсүгэй.

6. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Эрэнцав” ХК/Г.Одгэрэл/-д даалгасугай.

7. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН